

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙГ РЕДАКЦЫН БОДЛОГООР ЭРХЛЭЖ БУЙ ЗАРИМ ТУРШЛАГА

Д.Идэржаргал*, Р.Адъяасүрэн**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

**МУИС-ийн Жендэр судлал хөтөлбөрийн магистрант

Түлхүүр үгс: жендэр, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй, редакцын бодлого, тогтвортой хөгжил, эх сурвалж, BBC 50:50

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн бодлого гэдэг нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр жендэрийн тэгш байдал, хүртээмжтэй байдлыг дэмжих зорилгоор мэдээлэл олж авах, боловсруулах, түгээхтэй холбоотой болон редакцын бусад үйл ажиллагааг зохицуулж буй удирдамж, практик, тогтолцоог хэлдэг. Ийм бодлогын гол зорилго нь жендэрийн талаарх хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгах, бүх хүйсийн төлөөлөл, дүр төрхийг шударгаар харуулах явдал юм.

BBC, Bloomberg, Financial Times, Globe and Mail, The New York Times, Toronto Star зэрэг олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн жишиг бодлого хэрэгжүүлж, эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах, жендэрээр ялгаварлан гадуурхахгүй байх, нийтлэлийн бодлогоо сайжруулах, редак-

цын жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, хүний нөөцөө боловсруулах, ёс зүйн заавар журмуудаа шинэчлэх замаар амжилттай хэрэгжүүлснийг цөөнгүй судалгаанд дурджээ.

Энэхүү судалгаанд BBC агентлагийн 50/50 төслийг манай улсад туршихад гарч буй сорилт, бэрхшээлийн талаарх бодит туршлагыг өгүүлж, өнөөгийн нөхцөл байдалд бодлогын хувьд дүн шинжилгээ хийж, цаашид олон улсын жишгээр жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд анхаарах зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төслөөс анх удаа 1995 онд мэдээгээр гарсан хүмүүсийг хүйсээр нь ангилж үзэхэд ердөө 17 хувь нь эмэгтэйчүүд байж. Анхны мониторингоос хойш 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт 25 хувьд хүрсэн (Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төсөл, 2020). Өөрөөр хэлбэл, 25 жилийн хугацаанд ердөө 8 хувиар буюу жилд 0.32 хувийн өсөлт үзүүлсэн гэсэн үг. Энэ маягаар, энэ хурдаар явбал жендэрийн эрх

тэгш байдлыг сэтгүүл зүйн агуулгад харахын тулд бид дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэй болно.

2015 он болон 2020 онд хийсэн судалгааны өсөлт 1 хувь буюу өмнөх судалгаануудаас өссөн үзүүлэлттэй байгаа нь BBC, Bloomberg, Financial Times, Globe and Mail, The New York Times, Toronto Star зэрэг олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлж, эх сурвалжийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангахад идэвх санаачилгатай ажиллаж, шинэ арга барил, аргачлал нэвтрүүлж бусадтайгаа хуваалцаж байгаатай холбоотой гэж судлаачид дүгнэсэн байна (Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төсөл, 2020).

Дээрх судалгаанд дурдсанаар хэдийгээр мэдээний агуулга дахь эх сурвалжийн 25 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ч тэдгээрийг гэрийн ажил, эцэг эхийн үүргээр гаргаж байгаа нь дийлэнх буюу 68 хувьтай байна.

Монгол Улсын хувьд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн судалгаагаар өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн эх сурвалжийн 14 хувь, мэдээллийн сайтуудын 9.5 хувь нь л эмэгтэйчүүд байна. Улс төрийн бус эх сурвалжаар орж байгаа хувь үүнээс их боловч өмнө дурдсанчлан үүргийн хувьд хүйст хамааруулсан байдлаар гаргах нь их байна (Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2021).

“Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос

болгохгүй. Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвш-мэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ гэж Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд заасан” (<https://www.mediacouncil.mn/p/7>, n.d.).

Гэвч дээрх судалгаанд дурдсанчлан тэгш байдлыг хангах чиглэлд эрэгтэй, эмэгтэй хүйсийг ялгаатай гаргаснаас үүдэн хэвшмэл ойлголтыг дэвэргэж байна гэж дүгнэж болохоор байна.

Олон улсын туршлага. ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчдийн холбоо (ОУСХ) зэрэг байгууллагууд “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт” (Gender-Sensitive Indicators for Media)-ийг гаргасан бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой редакцын бодлогоо үнэлэхийг санал болгодог. Мөн Дэл-хийн Христийн Харилцааны Төлөөх Нийгэмлэг (World Association for Christian Communication) нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор 5 жил тутамд Глобал медиа мониторингийн төсөл (Global Media Monitoring Project) судалгааг хийж ирсэн. Эдгээр төслүүд нь жендэрийн тэгш байдлыг хангах, олон янз байдлыг, нийгмийн олон төлөөллийн тэгш оролцоог хангах тухай редакцын бодлоготой байхын ач холбогдлыг сурталчилдаг. Олон улсад жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн бодлого практикт дараах чиглэлээр хөгжиж байна.

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар редакцын бодлоготой болох. Үүний хүрээнд тодорхой төсөл, арга хэмжээнүүдийг зохион

- байгуулах. Эрх тэгш төлөөлөл буюу эх сурвалжийн төрөлжилтийг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдаж байгаа тул нийгмийн олон бүлгийн дуу хоолойг тэнцвэртэй хүргэхийн тулд мэдээллийн эх сурвалжийн санг сайжруулах нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хэвлэлүүд санаачилдаг болжээ. “Интерньюс”-ийн эх сурвалжийн дата сан болон “BBC” агентлагийн 50/50 төсөл нь олон улсад амжилтаараа танигдсан.
2. Хариуцлагын системийг сайжруулах. Хэвлэл мэдээллийн байгууллагууд жендэрээр ялгаварласан бүтээлийн талаар хянах, ирсэн гомдол саналыг шийддэг механизм байна. Үүнийг салбарын түвшинд ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага, мөн байгууллагын түвшинд редакцын ёс зүйн зарч-маараа дамжуулан зохицуулж байна. Хүйс болон бэлгийн олон янз байдлыг талаар үнэн зөв, ялгаварлан гадуурхалгүй, хор уршгийг буруулан мэдээлэх зохицуулалтыг ёс зүйн зарчимдаа тусгасаар иржээ.
3. Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгах. Нэгдүгээрт, хэлний хэрэглээнд анхаарч жендэрийн мэдрэмжтэй үг хэллэг сонгох, хоёрдугаарт, жендэрийн хэвшмэл ойлголт болон дүрслэлээс татгалзах, гуравдугаарт жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамттай холбоотой асуудлыг мэдрэмжтэй мэдээлэх тухай асуудлуудад бодлогын болон ёс зүйн зохицуулалтын түвшинд түлхүү анхаарч байна.
4. Редакцын жендэрийн тэгш байдлын нэмэгдүүлэх. Энэ нь нэгдүгээрт, ажилд авах, дэвших, удирдах албан тушаал жендэрийн олон янз байдлыг бий болгож, тэгш боломжоор хангах тухай; хоёрдугаарт, сэтгүүлч, хүний нөөцийг жендэрийн талаарх сургалтад тогтмол хамруулах; гуравдугаарт, ажлын байран дахь бэлгийн дарамт, гадуурхалтаас урьдчилан сэргийлэх; эдгээрт хамаарах бодлогыг төлөвлөх байдлаар хангагдаж байна.
- Олон улсын шилдэг туршлагаадаас харахад бүтээж байгаа агуулгадаа эмэгтэйчүүдийн олон талт төлөөллийг эх сурвалж болгон оруулахын тулд арга барилаа өөрчлөх хэрэгтэйг дурджээ. Тухайлбал, 2018 онд Bloomberg “Шинэ дуу хоолой” санаачилгыг эхлүүлсэн. Редакцын ярилцлагын зочноор ирж буй шинжээч эх сурвалжийн ердөө 10 хувь нь эмэгтэй байсан тул ийм арга хэмжээ авчээ. Тэд зураг, дүрс, эх сурвалжууддаа мониторинг хийж эхэлсэн бөгөөд анх улс төр, эдийн засаг, бизнес, технологийн салбарын эмэгтэй шинжээч олдохгүй, олдсон ч татгалзаж байсан байна. Санаачилгын хүрээнд эмэгтэй эх сурвалжийн жаг-саалтыг гаргаж, татгалзаж буй эх сурвалжуудад зориулсан хөтөлбөр боловсруулсан байна. Энэ бүхний үр дүнд 600 гаруй эмэгтэй болон төлөөлөл дутуу хэсгийг хэвлэл мэдээллийн сургалтад хамруулж, эмэгтэй эх сурвалжийн тоогоо гурав дахин нэмэгдүүлжээ. “Бид эмэгтэйчүүд болон төлөөлөл багатай мэргэжилтнүүдийн дуу хоолойг нэмэгдүүлснээр мэдээний хамрах хүрээ илүү тэнц-

вэртэй, бүрэн дүүрэн болсон” гэдгийг Bloomberg онцолсон байна (Bloomberg news agency).

Монгол Улсад жишиг болгон туршиж буй олон улсын нэр хүндтэй төсөл бол BBC-ийн Тэгш байдлын 50:50 төсөл юм. Тус агентлаг нь 2016-2020 оны “Олон янз байдал, оролцоог хангах стратеги”-ээ гаргахдаа хүний нөөц болон үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй болгох, агуулгаа төрөлжүүлэх, эх сурвалжид эзлэх эмэгтэйчүүдийн хувь, хэмжээг 50 хувьд хүргэх зорилтуудыг тус тус төлөвлөсөн байна. “BBC-гийн Лондон дахь редакц 2017 оноос эхлэн эх сурвалждаа мониторинг хийж, улмаар хяналтын зарчмаар тоог нэмэгдүүлснээр богино хугацаанд зорилтдоо хүрчээ. Улмаар энэхүү аргачлалаа ашиглан үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг нэмэгдүүлэхээр ажиллаж байна” (BBC-ийн 50/50 хөтөлбөрийн тайлан).

Өмнө дурдсан Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн 2020 оны судалгаагаар дүнгээр эмэгтэй эх сурвалжийн эзлэх хувь 1 хувиар өссөн нь дээрх томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудын шинэ санаачилга, түүнийгээ хуваалцаж буйтай холбоо-тойг дурдсан байдаг.

Монгол Улсын туршлага, ололт: Нэг. “Мэдрэмжтэй мэдээлье” төсөл. Бүтээлийн агуулгадаа тэгш байдлыг хангах аргачлалаа BBC бусад улс орны хэвлэл мэдээллийн салбарт хуваалцаж буй бөгөөд “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсаас “Зууны мэдээ сонин”, “GoGo.mn” сайт төслийн албан ёсны түнш болоод байна.

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг өргөн хүрээнд бий болгохоор 2021 онд Хэвлэлийн мэдээллийн зөвлөл болон Анлимитэд медиа группийн хамтарсан консорциумоос БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг үүсгэн байгуулсан.

Жендэрийн мэдрэмжтэй сурвалжилж бичих талаарх гарын авлага, сургалтын материал нэлээд бий. Тухайлбал, сэтгүүлч бэлтгэж буй их, дээд сургуулийн сургалтад зориулсан “Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй” (Жендэрийн үндэсний хороо, 2021) сэдэвт жишиг модуль сургалтын гарын авлага гарсан нь чухал ажил болжээ. Анхан шатны ойлголт, хүний эрхийг дээдэлсэн бүтээл хийхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Жендэрийн мэдрэмжтэй, ёс зүйтэй сэтгүүлч, редакторуудыг мэдлэг чадвараа сайжруулах, харилцан туршлага солилцох, салбартаа манлайлах, уншигч үзэгчдийнхээ итгэлийн хүлээх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой уг нэгдэл гурван жилийн хугацаанд менторшип хөтөлбөрт 11 редакцыг хамруулж, виртуал редакц болон бусад сургалтаар дамжуулан 1,551 хэвлэл мэдээллийн ажилтанд мэдээлэл өгсөн байна. Тус хөтөлбөрийн онцлог нь редакцын хөтөлбөрийн дагуу тухайн редакцын ерөнхий редактор, сэтгүүлчид төдийгүй гэрэл зурагчин, дизайнер, маркетинг хариуцсан ажилтнууд гээд бүхэлд нь

мэдээлэл өгснөөрөө давуу талтай болсон.

Төслийн хүрээнд менторшип хөтөлбөрт хамрагдсан редакцуудын зарим нь жендэрийн мэдрэмжтэй байдлыг бүтээлдээ тусгах талаар Редакцын бодлогодоо тусгасан байна (Мэдрэмжтэй мэдээлье нэгдлийн тайлан, 2024). Мөн эмэгтэй эх сурвалжийн дата санг бий болгохоос гадна зургийн санг бий болгож, ашиглах боломжийг олгосон байна.

Хоёр. BBC 50/50 төслийн туршилт.

GoGo.mn сайт 2022 онд BBC-гийн “50:50 The Equality Project” /Тэгш байдал төсөл/ төсөлтэй албан ёсоор түншилсэн Монголын анхны мэдээллийн сайт болсон. 50:50 төсөл нь үйл ажиллагаанд нийцүүлсэн сайн дурын, өөрийгөө хянах систем. Энэ нь энгийн бөгөөд уян хатан, өөрчлөлтийг бий болгох

дараах гурван үндсэн зарчимд суурилсан аргачлал юм. Үүнд,

- Өгөгдөл цуглуулах,
- Юуг хянаж чадахаа хэмжих,
- Чанарыг нягт баримтлах зарчмууд багтдаг.

Редакцууд өөрсдийн агуулгыг хянаж, агуулгаа боловсруулах явц-

даа эх сурвалжийн хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулж, дараа нь BBC-ийн төв оффистой сар бүр хуваалцдаг. Ингэхдээ зөвхөн өөрсдийн хяналтад байдаг хувь нэмэр оруулагчдыг л тооцдог. Тухайлбал, мэдээний агуулгын хувьд тухайн мэдээний гол эзэн болсон хүнийг (сонирхлын бүлгийн эх сурвалжийг) бүртгэхгүй, харин сурвалжлагч сонгож болох бусад эх сурвалжийг бүртгэдэг байна. Ингээд мэдээг сурвалжлах сэтгүүлч, ашиглах кэйс судалгаа, ярилцлага авах шинжээчдийг бүгдийг бүртгэх маягаар ажилладаг байна.

“Эх сурвалждаа өөрчлөлт хийхийн тулд дата цуглуулах нь хамгийн чухал. Өдөр бүр, долоо хоног бүр, сар бүр дата цуглуулснаар нийтлэл, телевиз, радиогийн нэвтрүүлгүүдээр хэр олон эмэгтэй эх сурвалж орж байгааг хянаж чадна. Түүнчлэн бид зөвхөн удирдаж чадах зүйлээ л бүртгэж, тоолдог. Өөрсдийн удирдаж чадах зүйл гэж юуг хэлээд байна вэ гэхээр нийтлэл, нэвтрүүлгээ хийхдээ хэнээс яриа авах, эш татахаа шийдэхдээ л эмэгтэй эх сурвалжуудыг давамгайл оруулж ирэх, шинэ дуу



GoGo.mn сайт 2022 онд BBC-гийн “50:50 The Equality Project” төсөлтэй албан ёсоор түншилсэн Монголын анхны мэдээллийн сайт болсон.

50:50 төсөл нь үйл ажиллагаанд нийцүүлсэн сайн дурын, өөрийгөө хянах систем.

Энэ нь энгийн бөгөөд уян хатан, өөрчлөлтийг бий болгох дараах гурван үндсэн зарчимд суурилсан аргачлал бөгөөд үүнд, өгөгдөл цуглуулах, юуг хянаж чадахаа хэмжих, чанарыг нягт баримтлах зарчмууд үйлчилдэг.

Редакцууд өөрсдийн агуулгыг хянаж, агуулгаа боловсруулах явцдаа эх сурвалжийн хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулж, дараа нь BBC-ийн төв оффистой сар бүр хуваалцдаг байна



байгааг хянаж чадна. Түүнчлэн бид зөвхөн удирдаж чадах зүйлээ л бүртгэж, тоолдог. Өөрсдийн удирдаж чадах зүйл гэж юуг хэлээд байна вэ гэхээр нийтлэл, нэвтрүүлгээ хийхдээ хэнээс яриа авах, эш татахаа шийдэхдээ л эмэгтэй эх сурвалжуудыг давамгайл оруулж ирэх, шинэ дуу

хоолой эрж хайх болдог" гэдгийг BBC-ийн 50:50 төслийн гадаад түнш эрхэлсэн ахлах мэргэжилтэн Миранда Холтт тодотгожээ.

Иймээс тус сайт бүртгэл хөтөлж эхэлсэн бөгөөд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн баг GoGo.mn сайтын контентод /мэдээ, нийтлэл, ярилцлага, сурвалжилга/-д мониторинг хийхэд нийт эх сурвалжийн 30

гаруй хувийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байсныг 40 хувьд хүргэхээр "Тэнцвэр" санаачилгыг мөн хэрэгжүүлж эхэлсэн байна. Ингэснээр зөвхөн хүйсийн тэгш байдлыг эх сурвалжийн, зураг өгүүлэмжийн түвшинд авч үзэж эхэлжээ. Цаашлаад цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн дуу хоолойг хүргэх талд ч мөн анхаарч ажиллахаар болоод байна.



Зураг №1. Gogo сайтын редакц "Тэнцвэр" санаачилгыг эхлүүлсэн талаараа зарласан нь.

ВBC-ийн 50:50 төслийн туршлага нь зөвхөн хүйсийн тэгш байдлыг хангахад чиглээгүй бөгөөд эх сурвалжийн түвшнээр мөн ялгаж бүртгэн сайжруулах чиглэлд ч ажилладаг нь тухайн редакцын хувьд чухал амжилт болсон гэв.

Эх сурвалжийн бүртгэл хөтлөх нь зөвхөн жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн хувьд ч биш редакцын тогтвортой хөгжлийн хувьд хаана яваагаа хэмжих, хэрхэн сайжруулах төлөвлөгөө гаргахад тус болж байна гэдгийг хэрэгжүүлэгч байгууллага дурдлаа.

ЭХ СУРВАЛЖИЙН бүртгэлийн хуудас

Эх сурвалжийн бүртгэлийн хуудсын энэхүү жишиг загварыг “Бодит байдлыг тусга” нөөц хэрэглэгдэхүүнээс авч, Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын өдөр тутмын ачаалалтай ажилд зориулан хялбарчилж, хөрвүүлсэн болно. Та бүхэн үүнийг хэрэгцээ шаардлагадаа тохируулан өөрчлөх боломжтой. Хэрвээ эх сурвалжийн бүртгэлийг илүү дэлгэрэнгүй хийхийг хүсвэл энэ холбоосоор анхдагч хувилбарыг татаж авна уу: <https://www.reflectreality.internews.org/resources>

КОНТЕНТ				ЭХ СУРВАЛЖИЙН ХҮЙС			
СЭДЭВ	БУЛАН	ЛИНК	Сэтгүүлч/Редактор	# эрэгтэй	# тодорхойгүй	# нийт эх сурвалж	% эмэгтэй
Эдийн засаг	Мэдээ	https://gogo.mn/r/jg401	Э.Энхмаа	2		5	60%
Эрүүл мэнд	Онцлох	https://gogo.mn/r/4x77n	А.Наранцацрал			1	100%
Спорт	Онцлох	https://gogo.mn/r/65e1y	Э.Энхмаа	4		9	56%
Улс төр	Мэдээ	https://gogo.mn/r/306030?i=	Л.Амарцэцэг	1		4	75%
Нийгэм	Онцлох	https://gogo.mn/r/lygd8	Г.Тэгшсүрэн	1		1	0%
Спорт	Мэдээ	https://gogo.mn/r/g72x9	Э.Энхмаа			1	100%
Нийгэм	Мэдээ	https://gogo.mn/r/m8xmw	Л.Амарцэцэг			1	100%
Нийгэм	Мэдээ	https://gogo.mn/r/dw58n	Б.Эрдэнэчимэг			1	100%
Соёл урлаг	Онцлох	https://gogo.mn/r/dw5dn	Б.Нямдарь			1	100%
Эрүүл мэнд	Онцлох	https://gogo.mn/r/vx98k	А.Наранцацрал			1	100%
Эдийн засаг	Онцлох	https://gogo.mn/r/qk187	Б.Азбаяр	1		1	0%
Эдийн засаг	Мэдээ	https://gogo.mn/r/8wq27	Б.Азбаяр	2		2	0%
Боловсрол	Онцлох	https://gogo.mn/r/x5odj	Б.Нямдарь	1		1	0%
Эрүүл мэнд	Мэдээ	https://gogo.mn/r/lyg3l	Б.Азбаяр			1	100%
Эдийн засаг	Мэдээ	https://gogo.mn/r/o3739	Э.Энхмаа	1		1	0%
Соёл урлаг	Мэдээ	https://gogo.mn/r/7v5xy	Л.Амарцэцэг			1	100%
Улс төр	Мэдээ	https://gogo.mn/r/klkxy	А.Наранцацрал			1	100%
Нийгэм	Мэдээ	https://gogo.mn/r/51q38	А.Наранцацрал			1	100%
Эрүүл мэнд	Онцлох	https://gogo.mn/r/g748d	Б.Азбаяр			1	100%

Зураг №2. Gogo сайт эх сурвалжийн бүртгэлийн хуудастаа эх сурвалжийг хүйсээр ангилж буй байдал.

Gogo.mn сайт нь жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг эрхлэх туршилтын хүрээнд редакцын бодлогодоо өөрчлөлт оруулж, өөрсдийн санаачилгыг буюу зорилтыг тодорхойлон зарласан бөгөөд тогтмол эх сурвалжийн бүртгэл хөтөлж, үнэлж байгаа нь редакц ямар салбарын асуудлыг илүү тусгаж буй талаараа шинжилгээ хийж болохоос гадна сэтгүүлч ажлаасаа гарсан ч эх сурвалж гэсэн том капитал байгууллагад үлдэх давуу талтай болжээ.

“Редакц чадавхжихын хэрээр шинэ залуу сэтгүүлчдийг сургах боломж бий болсон боловч бүртгэл бүртгэлийг тогтмол хийх буюу хэмжилт цаг авахаас гадна дадуулахад хүндрэлтэй тохиолдлууд байна. Монголын хэвлэл мэдээллийн сал-

барт хүн хүч дутмаг байгаа энэ үед тухайлсан нэг ажлын байр гаргах нь төвөгтэй тул давхар ажиллах шаардлага үүсэж буй нь тогтмолжуулахад хүндрэл үүсгэж байна. Мөн сүүлийн үед жендэр болон хэвшмэл ойлголтыг хэвлэл хэрхэн дэвэргэж буй талаар судалгаа байхгүй байгаа нь редакцууд энэ асуудлыг чухалд тооцохгүйд нөлөөлж байж болох юм” гэж жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг туршиж буй редакцын төлөөлөл үзэж байна.

БҮЛЭГ 2. НИЙТЛЭЛИЙН БОДЛОГО

- 2.1. Бид хараат бус, бие даасан, тэнцвэртэй мэдээллийг хүргэх үүднээс аливаа нам, улс төрийн хүчин, төрийн болон бизнесийн байгууллагын хяналтаас ангид олон нийтийн дуу хоолойг илэрхийлсэн, үндэсний эрх ашиг, нийгмийн үнэт зүйл, хүний эрх, шударга ёсыг дээдэлсэн зарчимтай, ёс зүйтэй мэдээллийг түгээнэ.
- 2.2. Бид түргэн шуурхай түгээхээс илүү нягталсан баталгаатай мэдээллийг хүргэхийг чухалчилж, мэдээллийн бодит байдлыг баталгаажуулахаас нааш ямар ч тохиолдолд олон нийтэд түгээхээс татгалзана.
- 2.3. Боловсрол, нийгэм, улс төр, эдийн засаг, спорт, соёл урлаг, технологи, дотоод болон гадаадын цаг үеийн мэдээлэл, сэтгүүлзүйн олон төрөлт контентыг хэрэглэгчид хүргэхээс гадна үншигчдыг хөтлөх, боловсруулах, соён гэгээрүүлэх үүргээ ухамсарлан ажиллана. Хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангасан, нийгмийг чиглүүлэх, түүчээлэх үүргээ чухалчлан үзнэ.
- 2.4. Мэдээлэлд холбоотой бүх талын эх сурвалжид тайлбар өгөх боломжийг ижил түвшинд олгоно.

Зураг №3. Gogo.mn сайт редакцын бодлогодоо жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн төлөөх зарчмыг оруулсан байдал.

Хэвлэл мэдээлэл хүмүүст юуны тухай бодохыг хэлж өгдөг хэмээн аженда сеттингийн онолд дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл дуу, дүрс, текст ээр дамжуулан бидний түгээж буй зүйлс хүмүүст ямар нэг сэжүүр, бодол, мэдээлэл өгч байдаг тул хүчтэй. Тэр дундаа сэтгүүл зүйн бүтээлээр дамжуулан олон талт байдлыг чухалчлан хүргэх үр нөлөө ихтэй нэг тоглогч. Энэ тоглогчоор дамжуулан бид жендэрийн мэдрэмж ямар чухал болохыг түүгээр дамжуулан бид ямар үр нөлөө гаргаж болохыг тайлбарлан таниулах, ахицтай ажиллах бүрэн боломжтойг жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг туршсан редакцуудын туршлагаас харж болохоор байна.

Сэтгүүл зүйн чанарын чухал хэмжүүр нь нийгмийн олон талт байдлыг бүрэн гүйцэд баримтад тулгуурлан, мэргэжлийн түвшинд хүргэх юм. Үүнийг хангахад жендэрийн мэдрэмжтэй бүтээл туурвих хэрэгцээ шаардлага чухал бөгөөд

бид дараах зөвлөмжийг хүргэж байна.

- Тухайн редакцын удирдлага, шийдвэр гаргах албан тушаалтнууд энэ талаарх ойлголтой байхаас гадна эд эс болсон сэтгүүлч, гэрэл зурагчин, зураглаачаас эхлээд бүх ажилтан мэдээлэлтэй байх нь хяналтын системийг бий болгох боломжтой тул редакцуудад зориулсан сургалтыг зохион байгуулах,
- Редакцын бодлого бол сэтгүүл зүйд чухал бичиг баримтад тооцогддог. Тухайн байгууллагын хийх болон хийхгүй байх агуулгын хүрээг хязгаарласан бичиг баримт байдаг тул бодлогодоо жендэрийн тэгш байдлыг хангах, олон янз байдлыг хамруулах, хэвшмэл ойлголтыг дэвэргэхгүй байх талаар тусгах,
- Бүртгэл хөтөлж, хэмжилтээр сайжруулах,
- Одоогийн нөхцөл байдлыг хэмжсэн бүрэн судалгаа хийх,

- Жендэрийн бодлого, жендэрийн мэдрэмжтэй ёс зүйн код, гарын авлага, хөтөч зэрэг холбогдох нөөцийг мэргэжлийн баг, хамт олонд таниулан сурталчилж, хэвлэл мэдээллийн практикт жендэрийн төлөвшлийг бүрдүүлэх зорилгоор сургалт, семинар зохион байгуулж, дэмжлэг үзүүлдэг байх зэрэг болно.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төсөл. (2020). Who Makes the News.
2. Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2021).
3. Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2015). Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим.
4. BBC-ийн 50/50 хөтөлбөрийн тайлан. <https://www.bbc.co.uk/5050>
5. Bloomberg-ийн Шинэ дуу хоолой төслийн тайлан. <https://www.bloomberg.com/company/values/diversity-and-inclusion/new-voices/>
6. Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооны ажлын алба. (2021). Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүлзүй хичээлийн хөтөлбөр.
7. Жендэрийн мэдрэмжтэй сурвалжилж бичих нь сургалтын гарын авлага. (2015)
8. Хэвлэлийн хүрээлэнгийн дэргэдэх Сэтгүүлч дээд сургууль. (2011).

Хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг хэрхэн дүрсэлж буй тандалт судалгаа.

9. Мэдрэмжтэй мэдээлье нэгдлийн тайлан. (2024).
10. Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага. (2014). Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт.
11. Мэдрэмжтэй мэдээлье нэгдэл. (2022). Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь Редакциудад зориулсан удирдамж.

Summary

The media sector plays a crucial role in ensuring gender equality by shaping public opinion. As one of the four key agents of socialization, the media is instrumental in providing and reinforcing gender awareness while challenging traditional stereotypes. This study examines gender-sensitive policies in journalism and the media sector, assessing their impact. It also highlights specific experiences from gender-sensitive journalism projects implemented in Mongolia.

Keywords: Gender, gender-sensitive journalism, editorial policy, sustainable development, sources, BBC 50:50, equality project.